
НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗАР

ТОВЧ АГУУЛГА

1. ТАНИЛЦУУЛГА.....
2. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР.....
3. ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭХ ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, БИЕЛЭЛТ.....
4. ӨМЧИЙН МЕНЕЖМЕНТ.....
5. ӨМЧИЙН ЭД ХӨРӨНГИЙН ХӨДӨЛГӨӨН, БҮРТГЭЛ.....
6. ӨМЧ ХУВЬЧЛАЛ.....

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗАР

Нийслэлийн Өмчийн харилцааны газар нь анх 1991 онд “Хотын Өмчийн газар” нэртэйгээр байгуулагдсан.

Засгийн газрын болон Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, нийслэлийн эдийн засаг, нийгмийн зорилтуудыг хэрэгжүүлэх нийслэлийн өмчийн талаар Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Засаг даргын баримтлах бодлого, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлоход мэргэжлийн зөвлөгөө үзүүлэх, нийслэлийн өмчийн ашиглалт, хамгаалалтыг хариуцаж, холбогдох шийдвэрийн биелэлтийг зохион байгуулж ажиллах үндсэн үүрэг бүхий Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг юм.



Эрхэм зорилго


- Нийслэлийн өмчийн харилцааны менежментийн оновчтой бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх замаар өмчийн үр ашиг, өгөөж, эдийн засгийн чадавхийг дээшлүүлэхэд оршино.

Үйл ажиллагааны стратегийн зорилт

- Нийслэлийн өмчийн харилцааны менежментийн бодлого, бодлогын хэрэгжилтийг зохицуулах, удирдлагаар хангах;
- Нийслэлийн өмчийн болон хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх;
- Захиргааны удирдлагын манлайлалыг хангах;
- Нийслэлийн төсвийн орлогын тодорхой хэсгийг бүрдүүлэх;
- Байгууллагын бодлогын хэрэгжилтэд хяналт, шинжилгээ хийж, үнэлгээ өгөх;

Байгууллагын түүхэн замнал





Захиргаа, санхүүгийн хэлтэс



Захиргаа, санхүүгийн хэлтэс нь төрийн албаны стандартын удирдлага, захиргааны болон хүний нөөцийн менежментийн үйлчилгээгээр хангах, Төсвийн тухай хууль, Төсвийн шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд олон улсын стандартыг нэвтрүүлж санхүүгийн программаар ханган бүртгэл хөтлөх, Нийслэлийн өмчийн захиран зарцуулалтад байнгын хяналт тавьж, өмчийн үр өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор нийслэлийн өмчийн байр талбайг иргэн, аж

ахуйн нэгж байгууллагад түрээслүүлэх, түрээсийн төлбөрийг цаг хугацаанд нь нийслэлийн төсөвт төвлөрүүлэх, байгууллагын дарга буюу албан тушаалтны хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд техник зохион байгуулалтын дэмжлэг үзүүлэх, байгууллагын үйл ажиллагааг тогтмолжуулан хэвийн ажиллах нөхцлийг бүрдүүлэх чиг үүрэгтэй ажиллаж байна.

Өмчийн бүртгэл, хувьчлалын хэлтэс



Нийслэлийн эд хөрөнгийн тооллого, бүртгэлийг эрхлэх, хөрөнгийн хөдөлгөөнийг холбогдох журмын дагуу хийж өмч хувьчлалын ажлыг зохион байгуулах, нийслэлд шинээр бий болж буй хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийг цаг алдалгүй бүртгэн, өмчийг эзэнтэй болгох.

Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтэс



Нийслэлийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх, нийслэлийн өмчийн ашиглалт, хамгаалалтад хяналт тавих хяналтын механизмыг сайжруулж, хяналтын системийг иж бүрэн боловсронгуй болгох, өмчийн харилцааны асуудлаар илэрсэн зөрчлийг арилгах, өмчийн эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх, өмчийн менежментийг сайжруулах, бодлогын хэрэгжилтийг ханган ажиллах.

Өмчийн мэдээлэл, хяналтын хэлтэс

Нийслэлийн өмчийн харилцааны газрын бодлого, стратегийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад хяналт шалгалт, үнэлгээ хийх, санал зөвлөмж гаргах, удирдлагыг мэдээллээр хангах.

Байгууллагын хэмжээнд мөрдөгдөж буй тогтоол, шийдвэр журмууд:

НИТХ-ын 2014 оны 01 сарын 23-ны өдрийн 14/01 дугаар тогтоол

- Нийслэлийн өмчийн талаар баримтлах бодлогын баримт бичиг /2014 - 2020/

НИТХТ-ийн 2014 оны 04 сарын 21-ний өдрийн 54 дүгээр тогтоол

- Нийслэлийн өмчийн хувь нийлүүлсэн хуулийн этгээдэд төлөөлөл хэрэгжүүлэх журам
- Нийслэлийн өмчийн хуулийн этгээдийн удирдах зөвлөлийн ажиллах журам
- Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын захиралтай контракт байгуулах, дүгнэх журам

НИТХТ-ийн 2014 оны 04 сарын 21-ний өдрийн 55 дугаар тогтоол

- Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ байгуулах, гэрээний биелэлтийг дүгнэх журам

НИТХТ-ийн 2014 оны 05 сарын 05-ны өдрийн 65 дугаар тогтоол

- Нийслэлийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журам
- Нийслэлийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх түрээслэгчийг сонгон шалгаруулах журам
- Нийслэлийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээ
- Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн ашиглалтгүй болон илүүдэлтэй ажлын байр, талбай, хөдлөх хөрөнгийн түрээсийн гэрээ

НИТХТ-ийн 2014 оны 05 сарын 05-ны өдрийн 66 дугаар тогтоол

- Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбоотой бусад харилцааг зохицуулах журам

НИТХТ-ийн 2014 оны 05 сарын 05-ны өдрийн 67 дугаар тогтоол

- Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбоотой бусад харилцааг зохицуулах журам

НИТХТ-ийн 2014 оны 05 сарын 05-ны өдрийн 68 дугаар тогтоол

- Нийслэлийн өмчид үнэ төлбөргүй шилжин ирж буй нийтийн эзэмшлийн эд хөрөнгийг бүртгэн авах тухай журам

НИТХТ-ийн 2014 оны 05 сарын 05-ны өдрийн 68 дугаар тогтоол

- Журамд нэмэлт өөрчлөлт оруулав.

Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хэрэгжүүлж буй төлөвлөгөө

- 1 • НӨХГ-ын стратеги төлөвлөгөө 2017-2020 он
- 2 • Байгууллагын үйл ажиллагааны 2017 оны төлөвлөгөө
- 3 • Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр
- 4 • Монгол Улсын Засгийн газрын “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 01 дүгээр албан даалгаврыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө /2017.10.26/
- 5 • Захирамжлалын баримт бичгийн хэрэгжилтийг эрчимжүүлэх ажлын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө
- 6 • Байгууллагын үйл ажиллагаанд байнга мөрдөж ажиллах заавар, журам, стандартыг хэрэгжүүлэх, 2017 оны үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх чиглэлээр шалган зааварлах ажлын хэсгээс өгсөн зөвлөмжийн дагуу хариу арга хэмжээний төлөвлөгөө
- 7 • Мэргэжлийн Хяналтын Ерөнхий газрын 2017 оны 01/2832 тоот зөвлөмжийн дагуу хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө
- 8 • “2017 онд шинээр санаачлан хийх ажлын төлөвлөгөө”
- 9 • “Агаар, орчны бохирдлыг бууруулах ажлын төлөвлөгөө ”
- 10 • Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн дүүргүүдэд ажилласан ажлын мөрөөр хийж хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө
- 11 • Нийслэл болон байгууллагын хэмжээнд 2017 онд зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөө
- 12 • НЗД-ын 2017 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 02 тоот албан даалгаврын дагуу хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө

Байгууллагын хэмжээнд дагаж мөрдөх дүрэм, журмыг шинэчлэн боловсруулж мөрдүүлэв:

- | | |
|---|--|
| НЗД-ын 2016 оны А/761 дүгээр захирамж | • НӨХГ-ын дүрэм |
| НӨХГ 2016 оны Б/356 дугаар тушаал | • Байгууллагын хэлтсүүдийн чиг үүрэг |
| 2016 оны А/537 дугаар тушаал | • Удирдлагын зөвлөлийн бүрэлдэхүүний ажиллах журам |
| 2016 оны А/411 дугаар тушаал | • Байгууллагын дотоод журам |
| 2017 оны А/226 дугаар тушаал | • Ёс зүйн хорооны бүрэлдэхүүн, |
| 2016 оны А/537 дугаар тушаал | • Ёс зүйн хорооны ажиллах журам |
| 2017 оны А/50 дугаар тушаал | • Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр |
| 2017 оны 02 сарын 10 - ны өдөр батлагдсан | • Авилгын эсрэг төлөвлөгөө |
| 2017 оны А/252 дугаар захирамж | • Албан хэрэг хөтлөлтийн ажиллах журам |

Нийслэлийн эдийн засаг нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт /92.5%/:

Нийслэлийн өмчийн авто замын бүртгэлийг сайжруулах, арчлалт хамгаалалтыг дээшлүүлэх зорилгоор гол авто замуудыг газрын кадастрт хамруулах, эзэмшил газрыг баталгаажуулах ажлыг зохион байгуулна. /90%/

Нийслэлийн өмчийн 40 - өөс дээш жил ашиглагдаж буй барилга байгууламжийн мэдээллийн санг бүрдүүлэх, барилга байгууламжуудын бат бэх, найдвартай байдалд үнэлгээ гаргуулна. / 90% /

Нийслэлийн өмчит үйлдвэрийн газруудын удирдлагын болон үргүй зардлыг үе шаттай бууруулна. /100%/

"Сургууль цэцэрлэгийн хоол, үйлдвэрлэл, үйлчилгээний нийтлэг шаардлага" боловруулж "Үдийн цай" хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж хүнсний аюулгүй байдлыг ханган ажиллах тогтолцоог бүрдүүлнэ. /90%/

Газрын даргын үр дүнгийн гэрээний биелэлт

"Байгууллагын үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө"-нд тусгагдсан 54 нийт арга хэмжээ /100%/

"Байгууллагын үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө"-нд тусгагдсан арга хэмжээнээс төсвийн ерөнхийлөн захирагчийн тусгайлан сонгосон 7 арга хэмжээ /98.3%/

Төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны манлайллын зорилтын хүрээнд 7 арга хэмжээ /100%/

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хүлээсэн 8 үүрэг биелэсэн

НЗДТГ- аас тус байгууллагын Газрын даргын үр дүнгийн гэрээг "Бүрэн хангалттай" гэж дүгнэсэн.

Тогтоол, шийдвэрийн хэрэгжилт

| № | Тогтоол, шийдвэрүүд | Тоо | Хэрэгжилт хувь |
|---|---|-----|----------------|
| 1 | Засгийн газрын тогтоол | 2 | 100% |
| 2 | Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол | 34 | 100% |
| 3 | Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоол | 2 | 100% |

| | | | |
|----|--|---------------------------------------|-------|
| 4 | Нийслэлийн Засаг даргын захирамж | 145 | 100% |
| 5 | НЗД-ын албан даалгавар | 2 | 100% |
| 6 | НЗД-ын Удирдлагын зөвлөлийн хурлын тэмдэглэл | 2 | 100% |
| 7 | Засгийн газрын албан даалгавар | 1 | 100% |
| 8 | Газрын даргын тушаал /А, Б/ | 1176 | 100% |
| 9 | Нийслэлийн Удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөн | 20 удаагийн хурал 65 үүрэг даалгавар | 100% |
| 10 | Байгууллагын шуурхай хурал | 22 удаагийн хурал 263 үүрэг даалгавар | 99.6% |
| 11 | Байгууллагын Удирдлагын зөвлөлийн хурал | 8 удаа | 100% |

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол:

| № | Төрөл | 2 |
|---|---|---|
| 1 | Хувьчлалын жагсаалт батлах тухай | 1 |
| 2 | Гудамж төслийн нэгжийг татан буулгаж, “Хөгжлийн хөтөч” дэд бүтцийг баталж, төсөл хэрэгжүүлэх нэгж байгуулах тухай | 1 |

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдэд өргөн барьж, шийдвэрлүүлсэн асуудлууд:

| № | Нийт | 34 |
|---|---|----|
| 1 | Нийслэлийн өмчийн хөрөнгийн хөдөлгөөний талаар | 31 |
| 2 | Нийслэл, дүүргийн өмчийн эд хөрөнгийн үзлэг, тооллогын мөрөөр авах арга хэмжээний тухай | 1 |
| 3 | Ногдол ашгийн хувь хэмжээг тогтоох тухай | 1 |
| 4 | Журамд өөрчлөлт оруулах тухай | 1 |

Нийслэлийн засаг даргын захирамж нийт 145 гарсан. Үүнээс байгууллагын үндсэн чиглэлтэй холбоотой 65 захирамж байна. Үүнд:

| № | Нийт | 65 |
|---|--|----|
| 1 | Нийслэлийн өмчийн хөрөнгийн хөдөлгөөний талаар | 59 |
| 2 | Зорилт батлах тухай | 1 |
| 3 | Нийслэлийн өмчийг гэрээгээр ашиглуулах тухай | 1 |
| 4 | Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох тухай | 1 |
| 5 | Урамшуулах олгох тухай | 1 |
| 6 | Өр барагдуулах тухай | 2 |

Газрын даргын тушаалууд:

| № | Тушаал | 1176 |
|---|---|------|
| 1 | Хөрөнгийн бүртгэл, хөдөлгөөнтэй холбоотой гарсан тушаал | 1016 |
| 2 | Ажлын хэсэг байгуулах тухай | 40 |


| | | |
|----|--|----|
| 3 | Спорт өдөрлөг зохион байгуулах тухай | 1 |
| 4 | Байгууллагын дэргэдэх баримт бичиг нягтлан шалгах комисс байгуулах тухай | 2 |
| 5 | Тооллогын комисс байгуулах тухай | 3 |
| 6 | Тамга тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хадгалах, ашиглах журам батлах тухай | 1 |
| 7 | Шатахууны лимит тогтоох тухай | 1 |
| 8 | Хариуцлагатай жижүүр, эргүүл томилон ажиллуулах тухай | 3 |
| 9 | Үнэлгээний хороо байгуулах тухай | 4 |
| 10 | Гэрээ дүгнэх тухай | 1 |
| 11 | Зардал гаргах тухай | 10 |
| 12 | Төрийн болон орон нутгийн өмчийн үзлэг, тооллогын мөрөөр авах арга хэмжээний тухай | 5 |
| 13 | Сахилгын хариуцлагыг дээшлүүлэх тухай | 1 |
| 14 | Барилга хүлээлцэх комисс томилох тухай | 1 |
| 15 | Зөвшөөрөл олгох тухай | 1 |
| 16 | Ёс зүйн хорооны ажиллах журам батлах тухай | 1 |
| 17 | Хувьчлагдах хуулийн этгээд, эд хөрөнгөд үнэлгээ хийлгүүлэх тухай | 1 |
| 18 | “Б” хүний нөөцийн чиглэлээр | 84 |

Ирсэн бичгийн шийдвэрлэлт:

| | Хэлтэс | Нийт | Шийдвэрлэлтийн хувь |
|---|--------------------------------------|------|---------------------|
| 1 | Захиргаа, санхүүгийн хэлтэс | 714 | 100% |
| 2 | Өмчийн бүртгэл, хувьчлалын хэлтэс | 1885 | 100% |
| 3 | Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтэс | 968 | 100% |
| 4 | Өмчийн мэдээлэл, хяналтын хэлтэс | 197 | 100% |
| | Нийт | 3764 | 100% |

Өргөдөл гомдлын шийдвэрлэлт:


Нийт 134 өргөдөл хүлээн авснаас хугацаандаа шийдвэрлэсэн 132, хугацаа хэтэрч шийдвэрлэсэн 2 өргөдөл байна. Тухайн зөрчил нь өдөрт нь хүлээн авч танилцаагүй гэсэн зөрчил байна. Өргөдөл, хүсэлтийг агуулгаар нь авч үзвэл 125 хүсэлт, 5 гомдол, 4 санал байгаа бөгөөд өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн байдал байгууллагын хэмжээнд 98,26% байна. “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам”-д заасан индексжүүлсэн үнэлгээгээр 0.458 байна.




Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн хугацааг өнгөрсөн оноос 44,1%-иар багасгалаа.



Шүүхэд хянан хэлэлцэгдэж буй хэргүүд /Нийт 23/



Байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдал



Байгууллагын цахим хуудсанд www.umch.ub.gov.mn/ үйл ажиллагаатай холбоотой болон цаг үеийн шаардлагаар зохион байгуулагдаж буй ажлуудын талаарх мэдээллийг байршуулан ажиллаж байна. Тайлант хугацаанд байгууллагын цахим хуудсанд нийт 35 орчим мэдээ мэдээллийг тухай бүрт нь шинэчлэн иргэдэд нээлттэй ил тод, түргэн шуурхай хүргэсэн

бөгөөд 2017 оны жилийн эцсийн байдлаар 222 954 хандалт авсан байна.

Бусад ажлын талаар

Онцлох үйл явдлууд:



Нийслэлийн өмчийн харилцааны газрын дарга Ч.Однасан, Монголын автобусны эзэд – жолооч нарын холбооны ерөнхийлөгч Х.Галмандах нар “Жолооч, тээвэрчдийн ногоон төгөл” байгуулахад хамтран ажиллахаар санамж бичиг байгуулж, солилцлоо.



Олон улсын ахмадын баяраар НӨХГ нь нийт 300-аад ахмад настанг хүлээн авч гарын бэлэг гардуулж хүндэтгэл үзүүллээ.



Нийслэлийн байгууллагад ажиллаж байсан ахмад настан болон хөдөлмөрийн чадвараа алдсан 2 иргэнд НЗД-ын захирамжаар үнэ төлбөргүйгээр орон сууц хувьчлан өглөө.




ОНӨҮГ-ын захирлуудыг чадваржуулах зорилгоор НЗДТГ-тай хамтран НӨҮГ-ууд болон төсөвт, төсөл хэрэгжүүлэгч 43 байгууллагын удирдлагыг оролцуулсан “Байгууллагын хөгжил, манлайлал” сэдэвт сургалтыг зохион байгуулав.



Нийслэлийн өмчийг эзэмших гэрээг дүгнэн “Бүрэн хангалттай” үнэлгээ авсан дараах байгууллагуудыг шалгаруулж өргөмжлөл гардуулав.

- Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газар
- Сонгинохайрхан дүүргийн 65 дугаар сургууль
- Чингэлтэй дүүргийн “Эрүүл Мэндийн төв”
- Баянзүрх дүүргийн 147 дугаар цэцэрлэг
- Сонгинохайрхан дүүргийн 163 дугаар цэцэрлэг.



Сургалт, арга хэмжээ:



2017 оны 05 сарын 15 –ны өдөр “Нээлттэй хаалганы өдөрлөг”



2017 оны 02 сарын 02-ны өдөр “Нээлттэй ажлын байр”-ны өдөрлөг





2017 оны 02 сарын 04-ний өдөр
“Мөнгөн Улаанбаатар-2017”



2017 оны 05 сарын 11-ны өдөр
“Улаанбаатар марафон - 2017”



2017 оны 10 сарын 13 –ны өдөр
“Бүх нийтийн их цэвэрлэгээ”



2017 оны 04 сарын 22-ны
“Спорт өдөрлөг”



2017 оны 12 сарын 14-ний өдөр
“Зөрчлийн тухай хууль” сургалтад
байгууллагын нийт албан хаагчид
хамрагдлаа

Шинээр санаачилсан ажлын талаар:



Албан хаагчдын санаачлагаар агаарын бохирдол ихтэй гэр хорооллын СХД-ийн Зүүн нарангийн 104 дүгээр цэцэрлэг, 9 дүгээр хорооны 163 дугаар цэцэрлэг, СБД-ийн 14 дүгээр хорооны 51 дүгээр цэцэрлэгүүдийг сонгон нийт 65 ажилтан, албан хаагчдын 1 өдрийн цалингаар агаар цэвэршүүлэгч, агаар шүүгчүүдийг худалдан авч хандивлалаа.




Бага насны архаг суурь өвчтэй хүүхдийг эмчилгээний хоол, сэргээн засах тусламж үйлчилгээгээр сувилан эрүүлжүүлэх үүрэг бүхий хүүхдийн клиник сувиллуудын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх “Бяцхан зүрх бүхний төлөө” аяны хүрээнд хүүхдийн живх, утлагын аппарат хандивлан хамт олноороо идэвхтэй оролцлоо.

ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭХ ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, БИЕЛЭЛТ

Байгууллагын 2017 оны санхүүжилт болох орон нутгийн төсвөөс 1 015 491,9 мянган төгрөг, жилийн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэх 449,869.0 мянган төгрөг нийт 1 460 360,9 мянган төгрөгийн төлөвлөгөө батлагдсанаас зардлын сар, улирлын хуваарийг Нийслэлийн Санхүү, Төрийн сангийн хэлтсээр батлуулан үйл ажиллагаандаа мөрдөн ажилласан. Батлагдсан төсвийн дагуу хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулан, орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх боломжийг судалж зохион байгуулан ажилласнаар төсвийн зарцуулалт өмнөх оныхоос 10 хувиар буурсан байна.


| № | Төсөвт төвлөрүүлэх орлого төрөл | 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар /өссөн дүнгээр/ | | | |
|------------|--|--|--------------------|---------------|-------------------|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хувь | Зөрүү |
| 1 | Түрээсийн орлого | 1 590 400.0 | 1 757 801,0 | 110,5% | -167 401,0 |
| 2 | Өмч хувьчлал | 5 000 000.0 | 5 038 531.0 | 101% | -38 531,0 |
| 3 | Ногдол ашиг | 1 100 000.0 | 1 103 748,2 | 100,3% | -3 748,2 |
| 4 | Актлагдсан хөрөнгө борлуулсан, автомашины дуудлага худалдааны орлого | 150 000.0 | 151 174,9 | 101% | -1 174,9 |
| Дүн | | 7 840 400.0 | 8 051 255,1 | 102,7% | -210 855,1 |

2016 оны гүйцэтгэлийг 2017 оны жилийн эцсийн гүйцэтгэлтэй харьцуулвал /мян.төг/




Түрээсийн гэрээ байгуулах, орлого төвлөрүүлэлтийн хэрэгжилт

Нийслэлийн төсөвт төвлөрүүлэх түрээсийн орлогын төлөвлөгөөг сар, улирал, жилээр хуваарь гарган Нийслэлийн Санхүү, Төрийн сангийн хэлтсээр батлуулж 2017 оны батлагдсан төлөвлөгөөнд **1 590 400,0 сая** төгрөгийн орлогыг төвлөрүүлэхээс **1 757 684,0** мянган төгрөгийг нийслэлийн төсөвт төвлөрүүлэн, төлөвлөгөөний биелэлтийг **110,5%** буюу **10,5%**-иар давуулан биелүүлсэн байна.



- Түрээсийн орлогын задаргаа:**
- Нийслэлийн Соёлын Төв Өргөөний 8754,2 м2 талбайг түрээсэлж;
 - 2016 оны жилийн эцэст үүссэн өр авлагыг барагдуулж ;
 - Ерөнхий боловсролын 95 сургуулийн цайны газрын түрээслэгч нартай хийсэн гэрээний дагуу ;
 - Бусад;

Нийслэлийн өмчийн байр, талбайг 341 иргэн, аж ахуйн нэгж байгууллагад түрээслүүлж **1 957,0 сая** төгрөгийн үнийн дүн бүхий 343 түрээсийн гэрээг боловсруулан бүртгэж баталгаажуулсан. Үүнд:




Ногдол ашиг төвлөрүүлэх талаар:

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар Орон нутгийн өмчит 7 үйлдвэрийн газар, нийслэлийн өмчийн оролцоотой 4 компанийн 2016 оны цэвэр ашгаас 2017 онд **866,426,800** төгрөгийн ногдол ашгийг нийслэлийн төсөвт төвлөрүүлэх тухай асуудлыг хэлэлцүүлэн 2017 оны 127 дугаар тогтоолоор батлуулсан. Тус тогтоолын дагуу 12 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар төсөвт төвлөрүүлэх ногдол ашиг **1 103 748,2** мянган төгрөг буюу **100,3%** -ийн гүйцэтгэлтэй биелэлтийг ханган ажилласан

| /мянган төгрөгөөр/ | | | | | | |
|--------------------|--|----------------------------------|---------------------------|--------------------------|--------------------|------|
| № | Байгууллагын нэрс | Нийслэлийн өмчийн оролцооны хувь | Ногдол ашиг тооцох хувь % | 2017 онд төвлөрүүлэх дүн | 2017 оны гүйцэтгэл | Хувь |
| 1 | Нийслэлийн Зураг төслийн хүрээлэн ОНӨААТҮГ | 100% | 30% | 64,400.6 | 57,960.5 | 90% |
| 2 | Хот тохижилтын газар ОНӨААТҮГ | 100% | 30% | 32,507.1 | 32,507.1 | 100% |
| 3 | Өсвөр үе хүнс ОНӨААТҮГ | 100% | 20% | 14,409.2 | 14,409.2 | 100% |
| 4 | Багачууд хүнс ОНӨААТҮГ | 100% | 20% | 7,407.0 | 7,407.0 | 100% |
| 5 | Асгат ОНӨААТҮГ | 100% | 20% | 5,509.8 | 5,509.8 | 100% |
| 6 | Хүнс хангамж төв ОНӨААТҮГ | 100% | 20% | 3,689.2 | 3,689.2 | 100% |
| 7 | Улаанбаатар зам засвар арчлалт ОНӨААТҮГ | 100% | 20% | 74.9 | 74.9 | 100% |
| 8 | Үндэсний соёл амралтын | 26% | 26% | 698,000.0 | 698,000.0 | 100% |

| | | | | | | |
|----------------|--|-----|-----|-----------|--------------------|---------------|
| | хүрээлэн ХХК /гэрээний дагуу/ | | | | | |
| 9 | Төв цэнгэлдэх хүрээлэн ХХК | 49% | 49% | 2,250.0 | 2,250.0 | 100% |
| 10 | Хишиг уул ХК | 37% | 37% | 1,106.6 | 1,106.6 | 100% |
| 11 | Монголын хөлөг онгоцны бүртгэл хамтарсан компани ХХК | 5% | 5% | 37,072.5 | 36,561.4 | 99% |
| Дүн | | | | 866,426.9 | 859,475.8 | |
| Урд оны авлага | | | | | 244,262.9 | |
| | | | | | 1,103,748.2 | 100.3% |



Акталж данснаас хассан хөрөнгийн талаар:

Газрын даргын 2017 оны 165 тушаалын дагуу хөрөнгө татан төвлөрүүлсэн.

Газрын даргын А/202 дугаар тушаалаар үнэлгээний комисс дахин үнэлгээ хийсэн.

Нийт 151,1 сая төгрөгийн худалдан борлуулалт хийн нийслэлийн төсөвт төвлөрүүлсэн

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН МЕНЕЖМЕНТ

Нийслэлийн өмчит үйлдвэрийн газруудын удирдлагын болон үргүй зардлыг үе шаттай бууруулах талаар:



Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/37 дугаар захирамжаар Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын захиралтай байгуулах Контрактын төсөл, 2017 оны эдийн засгийн үр дүнг дээшлүүлэх зорилтын төслийг бэлтгэх үүрэг бүхий “Ажлын хэсэг” байгуулан, орон нутгийн өмчит 33 үйлдвэрийн газруудын эдийн засгийн үр дүнг

дээшлүүлэх зорилтот түвшний төслийг хэлэлцүүлэн НЗД-ын 2017 оны А/181 дүгээр захирамжаар ОНӨҮГ-уудын 2017 оны эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтыг баталсан.

33 орон нутгийн өмчит үйлдвэрийн газар


22 аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар

11 төсөвт үйлдвэрийн газар

Орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын орлого, зардал, ашиг алдагдал

/сая. төгрөг/

| № | Үзүүлэлт | 2015 оны гүйцэтгэл | 2016 оны зорилт | 2016 оны биелэлт | 2017 оны зорилт | 2017 оны зорилтыг 2016 оны гүйцэтгэлтэй харьцуулбал |
|---|--|--------------------|-----------------|------------------|-----------------|---|
| 1 | Нийт орлого | 225 468,9 | 239 121,5 | 208 024,2 | 241 700,5 | 23 963,3 |
| 2 | Нийт зардал | 233 909,8 | 279 419,3 | 254 679,7 | 271 186,8 | 28 303,1 |
| 3 | Нийт ашиг, алдагдал | (8 441,0) | (24 207,3) | (46 655,5) | (29 461,3) | (17 641,3) |
| 4 | Борлуулалтын нэг төгрөгт ногдох зардал | 1,04 | 1,17 | 1,23 | 1,13 | (0,10) |



Судалгаа хийж, зөвлөмж хүргүүлэв.

ОНӨҮГ-уудын 2017 оны эхний хагас жилийн контрактын биелэлтэд судалгаа хийж, түүн дээр үндэслэн орлогын төлөвлөгөө биелүүлээгүй, ихээхэн хэмжээний алдагдалтай

ажилласан болон худалдан авалтыг шалгах зайлшгүй шаардлагатай үйлдвэрийн газруудад дараах зөвлөмжийг хүргүүлсэн.

Үүнд:

- 2017 оны Конрактын “Эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтот түвшний биелэлтийг ханган ажиллах;
- Байгууллагын батлагдсан зорилтот түвшний биелэлтийг ханган ажиллаж менежментийг сайжруулах, маркетингийн судалгаа, сурталчилгаа хийх, ашиг орлого нэмэгдүүлэх талаар төлөвлөгөө гарган өр авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авч, шинээр өр авлага үүсгэхгүй байх;
- Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 54 дүгээр тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчийн хуулийн этгээдийн Удирдах зөвлөлийн ажиллах журам”-ын 6 дугаар зүйлийн 6.1.2 дах заалтад нийцүүлэн Удирдах зөвлөлийн гишүүдийн цалинг шинээр тогтоох;
- Эдийн засгийн үр дүнг дээшлүүлэх зорилтод тусгагдсан цалин болон зайлшгүй хэрэгцээт зардлаас бусад зардлыг гаргахгүй байх;
- Худалдах, худалдан авах гэрээ байгуулахдаа Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн зааврын дагуу бараа, ажил үйлчилгээний үнэ, тоо хэмжээ, төлбөр хийх нөхцөл, гэрээний гүйцэтгэлийн хугацааг нарийвчлан заах;
- Контракт гэрээний 3.7-д заасан 30,000.0 мянган төгрөгөөс дээш үнийн дүн бүхий гэрээ хэлцэл хийхдээ Өмчийн харилцааны газарт хянуулж, зөвшөөрөл авах

Орон нутгийн өмчит 7 үйлдвэрийн газруудын бүтэц, зохион байгуулалт, дүрэмд өөрчлөлт оруулан орон тооны хязгаарыг шинэчлэн батлуулав.

| № | НЗД-ын захирамжийн дугаар | Батлагдсан огноо | Байгууллагууд |
|---|---------------------------|------------------|--|
| 1 | A/10 | 2017.01.07 | Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ |
| 2 | A/16 | 2017.01.09 | Үндэсний цэцэрлэгт хүрээлэн ОНӨТҮГ |
| 3 | A/59 | 2017.02.08 | Нийслэлийн орон сууцны корпорацн ОНӨААТҮГ |
| 4 | A/282 | 2017.05.16 | Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ |
| 5 | A/697 | 2017.09.20 | Замын хөдөлгөөний удирдлагын төв ОНӨТҮГ |
| 6 | A/698 | 2017.09.20 | Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар ОНӨААТҮГ |
| 7 | A/749 | 2017.10.05 | Ахмадын хотхон-1 ОНӨААТҮГ |

НӨҮГ болон Өмчийн оролцоотой компанийн ТУЗ, УЗ-д нийслэлийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх:

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 61 дүгээр тогтоолыг үндэслэн Нийслэлийн өмчийн оролцоотой хувь нийлүүлсэн хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөл, нийслэлийн өмчийн хуулийн этгээдийн Удирдах зөвлөлийн гишүүдийг шинэчлэн томилох тухай” НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 03 дугаар тогтоолоор тус газруудын УЗ, ТУЗ-ын гишүүдийг шинэчлэн томилуулсан.

Орон нутгийн Өмчит аж ахуйн тооцоот 12 үйлдвэрийн газруудын удирдах зөвлөлийн 34 удаагийн хуралд холбогдох мэргэжилтнүүд оролцож саналаа тусгуулж ажиллаа.

Үүнд:

- Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар-2
- Ус сувгийн удирдах газар 5
- Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар 5

- Хот тохижилтын газар 5
- Улаанбаатар зам засвар арчлалтын газар 2
- Нийслэлийн зураг төслийн хүрээлэн 2
- Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар 2
- Зорчигч тээврийн нэгтгэл 2
- Гэрлэх ёслолын ордон 3
- Нийслэлийн орон сууц санхүүжилтийн корпарац 2
- Үндэсний цэцэрлэгт хүрээлэн 2
- Геодези усны барилга байгууламжийн газар 2

Төсөвт газруудтай байгуулсан Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээг байгуулах дүгнэх:

Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээг 2017 онд:

635 байгууллага гэрээ дүгнүүлсэн.

Төр захиргааны
байгууллага 38


Эрүүл мэндийн
байгууллага 21

Төсөвт байгууллага
581


Гэрээг дүгнэх ажлыг 5 багц 14 үзүүлэлтээр 100 хүртэл оноогоор дүгнэж, илүүдэлтэй ажлын байр талбайгаа бусад иргэн, аж ахуй нэгжид түрээсэлдэггүй байгууллагыг 11 үзүүлэлтээр 85 хүртэл оноогоор дүгнэж, нийт авсан оноог хувиан дүнг гарган, дүгнэлтийг холбогдох зөвлөмжийн хамт тухайн байгууллагуудын удирдлагуудад танилцуулж баталгаажуулсан:

Сүүлийн 2 жилтэй харьцуулбал:

| | 2014 он | | 2015 он | | 2016 он | |
|------------------|---------|--------|---------|--------|---------|--------|
| | Тоогоор | Хувиар | Тоогоор | Хувиар | Тоогоор | Хувиар |
| Нийт | 597 | | 632 | | 635 | |
| Бүрэн хангалттай | 427 | 71,5% | 478 | 75,7% | 496 | 78,1% |
| Хангалттай | 129 | 21,6% | 131 | 20,6% | 114 | 17,9% |
| Ажил сайжруулах | 28 | 4,7% | 18 | 2,8% | 25 | 4% |
| Хангалтгүй | 13 | 2,2% | 5 | 0,9% | 0 | 0% |



Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээний 2016 оны дүгнэсэн байдал



Захиалагчийн хяналт тавьж ажилласан ажлын талаар:

"Эрх шилжүүлэх тухай" захирамж

НИТХ-ын 2017 оны 10/13 дугаар тогтоолыг үндэслэн НЗД-ын "Эрх шилжүүлэх тухай" нийт 19 захирамжийн хэрэгжилтийг ханган ажилласан.

1,027,080.4 мянган төгрөгийн санхүүжилтэд захиалагчийн хяналт тавин гэрээ байгуулж,

600,028.0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгуулж,

гэрээний хугацаа дуусаагүй **398,000.0** төгрөгийн,

29,051.6 мянган төгрөгийн барьцаа хөрөнгийг байршуулж, хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг нийслэлийн өмчид бүртгэн авч эзэмшил ашиглалтад хяналт тавьж ажиллах тухай газрын даргын тушаал гаргуулан батлуулж ажилласан.

Байгууллагуудаас зарласан тендерийн "Үнэлгээний хороо"

Нийт 7 байгууллагаас зарласан 15 тендерийн Үнэлгээний хороонд орж ажилласан. Үүнд:

- Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар- 5
- Ус сувгийн удирдах газар- 4
- Зорчигч тээврийн нэгтгэл-2
- Хот тохижилтын газар-1
- Өсвөр үе хүнс-1
- Багачууд хүнс-1
- НӨХГ-ын засварын ажил-1

Татан буугдсан газруудын өр төлбөрийг барагдуулах ажлын талаар:


Татан буугдсан 4 байгууллагын нийт **129 397 765,2** төгрөгийн өр төлбөрийг 2017 оны төсвийн тодотголд тусгуулах саналыг боловсруулан, Нийслэлийн Санхүү Төрийн сангийн хэлтэст хүргүүлж, Нийслэлийн Иргэдийн Хурлын 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн “Нийслэлийн 2017 оны төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 10/13 дугаар тогтоолд өр төлбөрийг барагдуулах хөрөнгийн эх үүсвэрийг батлуулан, хэрэгжүүлж ажиллаа.

| Нийслэлийн өмчит үлдвэрийн газруудын болон нийслэлийн өмчийн оролцоотой байгууллагын өр төлбөр | | | | |
|---|--|-----------------------|-------------------------|---|
| № | Байгууллагын нэр | Зардлын төлбөр | Өр төлбөрийн дүн | Зардлын нэр, задаргаа |
| 1 | "Ионсей найрамдал эмнэлэг" ХХК | 41,424,947.08 | 6,940,338.90 | НӨАТ |
| | | | 155,100.00 | Авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн татвар |
| | | | 1,245,606.00 | Цалин түүнтэй адилтгах орлого |
| | | | 3,564,452.00 | Үл хөдлөх хөрөнгийн татвар |
| | | | 14,976,623.00 | Татварын акт |
| | | | 4,431,045.18 | Нийгмийн даатгал |
| | | | 9,111,782.00 | Аж ахуйн нэгж байгууллага |
| | | | 1,000,000.00 | Хувь хүмүүс |
| 2 | "Уламжлалт эм, эмийн ургамал" ОНӨААТҮГ | 71,911,240.40 | 1,654,452.30 | А.А.Н-ийн орлогын албан татвар |
| | | | 29,562,865.50 | НӨАТ |
| | | | 3,391,517.50 | Цалин хөлс болон түүнтэй адилтгах орлого |
| | | | 2,022,400.00 | Үл хөдлөх хөрөнгийн татвар |
| | | | 35,280,005.10 | Татварын акт |
| 3 | УБ бизнес Хөгжлийн төв" ОНӨААТҮГ | 6,552,880.70 | 270,000.00 | Авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн татвар |
| | | | 6,282,880.70 | Шүүхийн шийдвэр |
| 4 | "УБ сан" ОНӨААТҮГ | 9,508,697.10 | 28,000.00 | Авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн татвар |
| | | | 1,737,949.80 | НӨАТ |
| | | | 7,742,747.30 | Цалин хөлс болон түүнтэй адилтгах орлого |
| Нийт дүн: | | 129,397,765.28 | | |

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ЭД ХӨРӨНГИЙН ХӨДӨЛГӨӨН

Нийслэлийн өмчид бүртгэлтэй эд хөрөнгийн талаарх мэдээлэл:

Нийслэлийн өмчийн эд хөрөнгийн үзлэг, тооллогын дүнгээр **770** байгууллагын нийт **2.346.209.6 сая** төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий эргэлтийн бус хөрөнгө байна.



| | | |
|---|---|---|
| Нийт 523 байгууллага барилга байгууламжтай | Балансын үнэ: 1,154,521,797,032.48 төгрөг | Барилга: 988,284,122,980.06 төгрөг |
| | | Байгууламж: 166,237,674,052.42 төгрөг |

Нийслэлийн өмчид бүртгэлтэй нийт барилгын задаргаа

| № | Барилгын төрөл | Тоо | Балансын үнэ |
|-----|---|-------------|---------------------------|
| 1 | Цэцэрлэгийн барилга | 305 | 161,682,884,228.23 |
| 2 | Сургуулийн барилга | 300 | 344,941,719,435.74 |
| 3 | Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн барилга | 53 | 3,993,488,898.90 |
| 4 | ОНӨААТҮГ-н барилга | 1583 | 157,154,179,224.79 |
| 5 | Эрүүл мэндийн байгууллагуудын барилга | 140 | 114,561,251,747.85 |
| 6 | Цагдаагийн байгууллагын барилга | 81 | 19,720,115,049.92 |
| 7 | Онцгой байдлын газруудын барилга | 37 | 8,616,647,229.00 |
| 8 | Дүүргийн төр захиргааны байгууллагуудын барилга | 353 | 117,049,635,249.06 |
| 9 | Нийслэлийн төр захиргааны байгууллагуудын барилга | 142 | 60,564,201,916.57 |
| Дүн | | 2994 | 988,284,122,980.06 |

Барилгыг насжилтаар нь ангилбал:

| № | Ашиглалтанд орсон он | Ашигласан жил | Барилгын тоо |
|---|----------------------|-------------------|--------------|
| 1 | 1960 оноос өмнөх | 58-с дээш | 105 |
| 2 | 1961-1970 | 48-58 | 174 |
| 3 | 1971-1980 | 38-48 | 370 |
| 4 | 1981-1990 | 28-38 | 457 |
| 5 | 1991-2000 | 18-28 | 253 |
| 6 | 2001-2010 | 8-18 | 779 |
| 6 | 2011 оноос хойшхи | 7 ба түүнээс бага | 856 |
| | БҮГД ДҮН | | 2994 |

Нийт 305 байгууллагад 158,953,150,373.97 төгрөгийн 2044 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байдаг. Үүнд:

| № | Автомашины төрөл | Тоо |
|---|--------------------------|-------------|
| 1 | Жип | 77 |
| 2 | Суудлын автомашин | 726 |
| 3 | Автобус микроавтобус | 349 |
| 4 | Трактор механизм | 42 |
| 5 | Ачааны машин | 405 |
| 6 | Мотоцикл | 143 |
| 7 | Тусгай зориулалтын машин | 302 |
| | | 2044 |

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдэд өргөн барьж шийдвэрлүүлсэн хөрөнгийн хөдөлгөөнтэй холбоотой асуудлууд:

| № | Төрөл | Нийт 31 |
|---|---|------------|
| 1 | Нийслэлийн өмчид хөрөнгө бүртгэх тухай | 18 |
| 2 | Нийслэлийн өмчид орон сууцны барилга байгууламж бүртгэх тухай | 2 |
| 3 | Нийслэлийн өмчийн бүртгэлээс орон сууц хасаж, хувьчлах тухай | 2 |
| 4 | Нийслэлийн өмчийн бүртгэлээс барилга байгууламж хасах тухай | 7 |
| 5 | Барилга байгууламж балансаас балансад шилжүүлэх тухай | 2 |

Нийслэлийн Засаг даргын хөрөнгийн хөдөлгөөнтэй холбоотой гаргасан захирамжууд:

| № | Төрөл | Нийт 59 |
|---|--|------------|
| 1 | Нийслэлийн өмчид хөрөнгө бүртгэх тухай | 28 |
| 2 | Нийслэлийн өмчийн бүртгэлээс хөрөнгө хасах тухай | 12 |


| | | |
|---|---|----|
| 3 | Хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай | 13 |
| 4 | Тээврийн хэрэгсэл худалдаж авч, нийслэлийн өмчид бүртгэж авах | 2 |
| 5 | Нийслэлийн өмчийн бүртгэлээс хөрөнгө хасаж, хувьчлах тухай | 2 |
| 6 | Тээврийн хэрэгсэл худалдаж авах тухай | 4 |

Газрын даргын хөрөнгийн хөдөлгөөнтэй холбоотой гаргасан тушаалууд:

| № | Төрөл | Нийт 1016 |
|---|--|--------------|
| 1 | Эргэлтийн бус хөрөнгө бүртгэх тухай | 393 |
| 2 | Эргэлтийн бус хөрөнгө данснаас хасах тухай | 459 |
| 3 | Эргэлтийн бус хөрөнгө балансаас балансад шилжүүлэх | 164 |

Нийслэлийн өмчийн эд хөрөнгийн бүртгэлийн ажлын талаар:

Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт, гадаадын зээл, буцалтгүй тусламж, гадаад дотоодын хандив бэлэглэлээр нийслэлийн өмчид шинээр бий болсон эд хөрөнгийг эзэмшигч байгууллагын данс бүртгэлд тусгах, нийслэлийн өмчит хуулийн этгээдийн хүсэлтийг үндэслэн дансны залруулга хийх, ашиглалтын шаардлага хангахгүй болсон эд хөрөнгийг акталж, данснаас хасах асуудлыг шийдвэрлэх, нийслэлийн өмчит болон нийслэлийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хүлээн авч, тухайн онд хийгдсэн үндсэн хөрөнгийн хөдөлгөөн, өөрчлөлтийг өмчийн мэдээллийн санд бүрэн гүйцэд оруулсан эсэхийг шалгах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:



Нэг. Барилга байгууламж - 115 нэрийн 104 050,0 сая төгрөг

| № | Тогтоол | Эх үүсвэр | Байршил | Барилга, байгууламж | Хөрөнгийн дүн |
|-----|--|---|----------------------------------|---|---------------------|
| 1. | “Нийслэлийн өмчид орон сууц бүртгэн авах тухай” 05 дугаар тогтоол | Төрийн орон сууцны корпорацийн захиалгаар, нийслэлийн төсвийн хөрөнгөөр худалдан авсан. | ХУД-ийн 16 дугаар хороо | 30 айлын орон сууц | 1 737,8 сая төгрөг |
| 2. | “Нийслэлийн өмчид эд хөрөнгө бүртгэн авах тухай” 06 дугаар тогтоол | “Дэлхийн боловсрол” ХХК – ийн хөрөнгөөр баригдсан. | БГД-ийн 18 дугаар хороо | 207 м ² бүхий автомашины зориулалттай зоорийн давхар | 84 сая төгрөг |
| 3. | “Нийслэлийн өмчид эд хөрөнгө бүртгэн авах тухай” 07 дугаар тогтоол | Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар баригдсан. | СБД-ийн 18, 20 дугаар хороо | 2 гүний худаг | 75,4 сая төгрөг |
| 4. | “Нийслэлийн өмчид хөрөнгө бүртгэн авах тухай” 08 дугаар тогтоол | Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр баригдсан. | Баянгол, Чингэлтэй дүүргүүдэд | Ус түгээх 4 байр | 128,8 сая төгрөг |
| 5. | “Нийслэлийн өмчид хөрөнгө бүртгэн авах тухай” 09 дугаар тогтоол | Улаанбаатар хэвлэл ХХК-ийн хөрөнгө оруулалтаар баригдсан. | СБД-ийн 8 дугаар хороо | “Сити таувэр” барилгын 3 дугаар давхар | 563,8 сая төгрөг |
| 6. | “Нийслэлийн өмчид хөрөнгө бүртгэн авах тухай” 10 дугаар тогтоол | БНД-ийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэрт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан | Багануур дүүргийн 1 дүгээр хороо | 235 дугаар цэцэрлэгийн барилга | 1 073,3 сая төгрөг |
| 7. | “Нийслэлийн өмчид хөрөнгө бүртгэн авах тухай” 11 дүгээр тогтоол | Улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар | Баянгол, дүүрэг | 5 барилга байгууламж | 10 367,7 сая төгрөг |
| 8. | “Нийслэлийн өмчид хөрөнгө бүртгэн авах тухай” 12 дугаар тогтоол | Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт | СХД, БНД | 8 барилга байгууламж | 9 566,6 сая төгрөг |
| 9. | “Нийслэлийн өмчид хөрөнгө бүртгэн авах тухай” 31 дүгээр тогтоол | Улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан. | БГД | 3 барилга байгууламж | 4 597,7 сая төгрөг |
| 10. | “Нийслэлийн өмчид орон сууцны барилга | АХБ-ны зээлээр хэрэгжиж байгаа УБ хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө | СХД-ийн 8 дугаар хороо | Үйлчилгээтэй 50 айлын орон сууцны барилга | 3 397,9 сая төгрөг |

| | | | | | |
|-----|--|---|---|--|----------------------|
| | байгууламж бүртгэх тухай” 32 дугаар тогтоол | орруулалтыг дэмжих хөтөлбөр | | | |
| 12. | “Нийслэлийн өмчид хөрөнгө бүртгэн авах тухай” 52 дугаар тогтоол | Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт | БНД, БЗД, ЧД, НД-ийн нутаг дэвсгэрт | 5 барилга байгууламж | 5 114,0 сая төгрөг |
| 13. | “Нийслэлийн өмчид хөрөнгө бүртгэн авах тухай” 96 дугаар тогтоол | Улсын төсвийн хөрөнгө оруулалт | БЗД-ийн нутаг дэвсгэрт | 8 айлын орон сууцны 2 барилга | 540,5 сая төгрөг |
| 14. | “Нийслэлийн өмчид хөрөнгө бүртгэн авах тухай” 97 дугаар тогтоол | Улсын төсвийн хөрөнгө оруулалт | СХД, НД, ХУД-ийн нутаг дэвсгэрт | 7 барилга, 2 гүний худаг | 17 552 ,2 сая төгрөг |
| 15 | “Нийслэлийн өмчид хөрөнгө бүртгэн авах тухай” 123 дугаар тогтоол | ААНБ, иргэдээс нийслэлийн өмчид үнэ төлбөргүй шилжүүлж байгаа | БГД, БЗД, ХУД, ЧД, СХД, Налайх дүүргүүдэд | 171 орон сууцны барилгын ус дулааны, гадна шугам сүлжээ, тоног төхөөрөмж | 6 314,3 сая төгрөг |
| 16. | “Нийслэлийн өмчид хөрөнгө бүртгэн авах тухай” 124 дүгээр тогтоол | Хөгжлийн банкны санхүүжилт | Буянт-Ухаа-1, 2 хороололд | Цэцэрлэгийн 3 барилга | 3 535,8 сая төгрөг |
| 17. | “Нийслэлийн өмчид хөрөнгө бүртгэн авах тухай” 125 дугаар тогтоол | Хөгжлийн банкны санхүүжилт | СХД, СБД, ХУД-ийн нутаг дэвсгэрт | Дэд бүтцийн барилга байгууламжийн шугам сүлжээ, тоног төхөөрөмж | 8 413,9 сая төгрөг |
| 18. | “Нийслэлийн өмчид хөрөнгө бүртгэн авах тухай” 126 дугаар тогтоол | Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт | ЧД-ийн нутаг дэвсгэрт | Барилга байгууламж | 6 914,7 сая төгрөг |
| 19. | “Нийслэлийн өмчид хөрөнгө бүртгэн авах тухай” 162, 170, 171 дүгээр тогтоол | Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт | БЗД, СХД, СБД, ХУД, ЧД | 21 барилга байгууламж | 24 071,6 сая төгрөг |

Нийслэлийн өмчид бүртгэн авсан томоохон барилгууд:

Буянт-Уха 1 хороолол, 30 айлын орон сууц



БНД, 1 дүгээр хороо, 235 дугаар цэцэрлэг



СХД, 8 дугаар хороо, Үйлчилгээтэй 50 айлын орон сууц



"Сити таувэр" барилгын 3 давхар

Хоёр. Тээврийн хэрэгсэл – 12 нэрийн 4 909,9 сая төгрөгийн 65 тээврийн хэрэгсэл

| № | Нийслэлийн Засаг даргын захирамж | Хөрөнгийн дүн | Тээврийн хэрэгслийн тоо |
|-----|--------------------------------------|--------------------|-------------------------|
| 1. | 2017.05.30-ны А/366 дугаар захирамж | 98,2 сая төгрөг | 4 |
| 2. | 2017.11.03-ны А/825 дугаар захирамж | 3 809,6 сая төгрөг | 22 |
| 3. | 2017.11.14-ний А/858 дугаар захирамж | 92,2 сая төгрөг | 3 |
| 4. | 2017.12.25-ны А/1038 дугаар захирамж | 380,4 сая төгрөг | 21 |
| 5. | 2017 А/913 дугаар захирамж | 42,2 сая төгрөг | 3 |
| 6. | 2017.11.29-ний А/914 дүгээр захирамж | 98,8 сая төгрөг | 2 |
| 7. | 2017.12.11-ний А/952 дугаар захирамж | 35 сая төгрөг | 1 |
| 8. | 2017.12.11-ний А/954 дүгээр захирамж | 41,9 сая төгрөг | 3 |
| 9. | 2017.12.28-ны А/1047 дугаар захирамж | 269,6 сая төгрөг | 3 |
| 10. | 2017.12.28-ны А/1049 дүгээр захирамж | 41,9 сая төгрөг | 3 |

Гурав. ЭБХХХК-ын хурлаар бүртгэсэн эд хөрөнгө – 5 468,9 сая төгрөг

Төсөл хөтөлбөр, хандив бэлэглэлээр ирсэн тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг үндсэн хөрөнгөдөө бүртгэх зөвшөөрөл хүссэн байгууллагуудын хүсэлтийг комиссын хурлаар хэлэлцүүлж, давхардсан тоогоор **446** байгууллагын **5 468,9 сая** төгрөгийн эд хөрөнгийг бүртгэх Газрын даргын тушаалыг гаргасан. Үүнд:

- Баянгол дүүргийн 53 байгууллагын 484,25 сая төгрөгийн
- Баянзүрх дүүргийн 152 байгууллагын 950,2 сая төгрөгийн
- Сонгинохайрхан дүүргийн 56 байгууллагын 677,9 сая төгрөгийн

- Сүхбаатар дүүргийн 69 байгууллагын 1 064,8 сая төгрөгийн
- Хан-Уул дүүргийн 39 байгууллагын 307,5 сая төгрөгийн
- Чингэлтэй дүүргийн 54 байгууллагын 1 705,8 сая төгрөгийн
- Налайх дүүргийн 7 байгууллагын 55,0 сая төгрөгийн
- Багануур дүүргийн 15 байгууллагын 77,9 сая төгрөгийн
- Багахангай дүүргийн 1 байгууллагын 5,75 сая төгрөгийн
- ОСНААУГ-ын шугам сүлжээ – 139,76 сая төгрөгийн

Дөрөв. Шинээр бий болсон эд хөрөнгийг данс бүртгэлдээ бүртгэн авах тухай албан бичиг хүргүүлсэн байдал – 69 325,64 сая төгрөг

Үүнд:

- Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2017 онд санхүүжүүлэх 72 493,2 төгрөгийн 202 ажил
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэх нийслэлийн Засаг даргад эрх шилжсэн 2 049,8 сая төгрөгийн 19 ажил
- Замын сангийн хөрөнгөөр санхүүжих 27 727,4 сая төгрөгийн 42 ажил
- Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжих 7 837,7 сая төгрөгийн 168 ажил
- Монгол улсын 2017 оны төсвийн тухай хуульд тусгагдсан 108 231,2 сая төгрөгийн 55 ажил


Данснаас хассан хөрөнгийн талаар:

Тайлант хугацаанд 2 102,48 сая төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий барилга байгууламж, 9 108,5 сая төгрөгийн хөдлөх хөрөнгө, 2 830,9 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл нийт 14 041,8 сая төгрөгийн эд хөрөнгийг нийслэлийн өмчийн бүртгэлээс хасах асуудлыг шийдвэрлүүлээд байна.

| № | Шийдвэр | Мөнгөн дүн | Хөрөнгө |
|-----|--------------------------------------|------------------|--|
| 1. | НИТХТ-ын 2017 оны 04 дүгээр тогтоол | 70,8 сая төгрөг | 5 барилга байгууламж |
| 2. | НИТХТ-ын 2017 оны 46 дугаар тогтоол | 29,4 сая төгрөг | ХУД-н 3 хорооны 50 дугаар байрны 3 тоот |
| 3. | НИТХТ-ын 2017 оны 64 дүгээр тогтоол | 317,2 сая төгрөг | БЗД-н 3 хороо 15 автомашины гараж, зам талбай |
| 4. | НИТХТ-ын 2017 оны 65 дугаар тогтоол | 755,0 сая төгрөг | СБД-н 54 дүгээр цэцэрлэгийн барилга |
| 5. | НИТХТ-ын 2017 оны 129 дүгээр тогтоол | 40,5 сая төгрөг | СБД-н 13 хороо 150 дугаар цэцэрлэгийн уурын зуух |
| 6. | НИТХТ-ын 2017 оны 140 дүгээр тогтоол | 23,8 сая төгрөг | СХД-н 12 дугаар сургуулийн агуулах |
| 7. | НИТХТ-ын 2017 оны 161 дүгээр тогтоол | 2,0 сая төгрөг | БНД-н ЗДТГ-ын гараж |
| 8. | НИТХТ-ын 2017 оны 163 дугаар тогтоол | 12 сая төгрөг | СХД-н 26 хороонд байрлах 8 авто машины гараж |
| 9. | НИТХТ-ын 2017 оны 172 дугаар тогтоол | 44 сая төгрөг | “Хот тохижилтын газар” ОНӨААТҮГ балансад бүртгэлтэй автобазын 10 барилга |
| 10. | НЗД-ын А/237 дугаар захирамж | 17 сая төгрөг | БЗД, ЧД-н Ус түгээх байрууд |
| 11. | НЗД-ын А/314 дүгээр захирамж | 781,3 сая төгрөг | ХУД-н 46 цэцэрлэгийн барилга байгууламж |


| | | | |
|-----|------------------------------|-----------------|--|
| 12. | НЗД-ын А/367 дугаар захирамж | 52,7 сая төгрөг | СХД-н цагдаагийн байрны өргөтгөл, Өрхийн эрүүл мэндийн төвийн байр |
|-----|------------------------------|-----------------|--|

Данснаас хассан тээврийн хэрэгсэл



“Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын хурлыг зохион байгуулах:

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2016 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн А/100 тоот тушаалаар батлагдсан Эргэлтийн бус хөрөнгийг хөдөлгөөн хариуцсан комисс нь 2017 оны 01 дүгээр сарын 01-нээс 12 дугаар сарын 28-ны өдрийг хүртэлх хугацаанд 42 удаа хуралдаж давхардсан тоогоор нийт 1088 байгууллагын 12 202 нэр төрлийн **26 122 739 688** төгрөгийн эд хөрөнгийн худалдан авах, шинээр бүртгэх, балансаас балансад шилжүүлэх, данснаас дансанд шилжүүлэх, данснаас хасах асуудлыг холбогдох хууль, журмын дагуу хэлэлцэн шийдвэрлэж ажиллалаа.



ӨМЧ ХУВЬЧЛАЛ

Өмч хувьчлалын ажлын талаар:

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 6/13 дугаар тогтоолоор 2017 онд хувьчлагдах 2 барилга байгууламжийн жагсаалтыг, Нийслэлийн Засаг даргын 2017.05.09-ний өдрийн А/287 дугаар захирамжаар хувьчлах эд хөрөнгийн жагсаалтанд шинээр орсон 2 барилга байгууламж, хариуцан ажиллаж байсан Итгэмжлэгдсэн төлөөлөгч нь өөрчлөгдсөн 5 барилга байгууламж, нийт 7 барилга байгууламжийн хувьчлалыг хариуцан ажиллах Итгэмжлэгдсэн төлөөлөгчдийг томилуулав.

Нийслэлийн Өмч хувьчлах комиссын хурлыг нийт 4 удаа зохион байгуулж, 39 асуудал хэлэлцүүлэн 32 тогтоол гаргуулан хэрэгжилтийг ханган ажиллалаа.

Үүнд:

- Шинээр дуудлагын худалдаагаар хувьчлах: **3 ТОГТООЛ**
- Санал болгон хувьчлах тухай: **2 ТОГТООЛ**
- Дахин дуудлагын худалдаа зохион байгуулах тухай: **8 ТОГТООЛ**
- Өмчлөгчийн эрх олгох тухай: **10 ТОГТООЛ**
- Хувьчлалын тайлан батлах тухай: **9 ТОГТООЛ**

Тайлант хугацаанд Нийслэлийн өмч хувьчлалын нээлттэй дуудлагын худалдааг нийт 8 удаа зохион байгуулахаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарласан ба 5 удаагийн дуудлагын худалдаанд оролцогчийн санал ирүүлээгүй болно. Дараах 3 удаагийн дуудлага худалдаанд санал ирж, нийт 8 барилга байгууламжийг хувьчилснаас нийслэлийн төсөвт **5 038 529 000** төгрөгийг төвлөрүүлсэн байна.



Байршил:



Хан-Уул дүүргийн 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт буюу Өлзийт тосгоны төвд байрладаг

Хувьчлагдсан үнэ:

37 462 000 төгрөг



Байршил:



Сүхбаатар дүүргийн 13-р хороо, Рашааны 8-18 тоот

Хувьчлагдсан үнэ:

65 900 000 төгрөг



Байршил:

Хувьчлагдсан үнэ:



Хан-Уул дүүргийн 7-р хороо,
Яармагийн 8-518 тоот

63 800 000 төгрөг




Байршил:

Хувьчлагдсан үнэ:



Хан-Уул дүүргийн 5-р хороо,
Яармагийн 21-р гудамж 610 б тоот

60 640 000 төгрөг



Байршил:

Хувьчлагдсан үнэ:



Чингэлтэй дүүргийн 1 дүгээр хороо,
Бага тойруу-3, Ц.Жигжиджавын гудамж-9

4 360 000 000 төгрөг



Байршил:

Хувьчлагдсан үнэ:



Баянгол дүүргийн 19-р хороо
4-р хороолол, Модны-2

103 500 000 төгрөг



| | |
|-------------------|---|
| Байршил | Баянзүрх дүүргийн 3 дугаар хороонд байрлах Сансар үйлчилгээний төвийн баруун жигүүрийн 2 дугаар давхарт |
| Хувьчлагдсан үнэ: | 313 227 000 төгрөг |



| | |
|-------------------|---|
| Байршил: | Чингэлтэй дүүрэг 1 дүгээр хороо, Ц.Жигжиджавын гудамж |
| Хувьчлагдсан үнэ: | 34 000 000 төгрөг |

Тээврийн хэрэгслийн дуудлага худалдааны талаар

Тээврийн хэрэгслийн Нээлттэй дуудлагын худалдааг 2017 онд 5 удаа холбогдох хууль, дүрэм, журмын дагуу зохион байгуулж, нийт 40 байгууллагын 58 тээврийн хэрэгслийг 106,940,000 төгрөгөөр худалдан борлуулж Нийслэлийн төсөвт 85,040,000 төгрөгийн орлого төвлөрүүлээд байна.

| № | Огноо | Байгууллагын тоо | Тээврийн хэрэгсэл |
|-------------------------------------|----------------------|------------------|-------------------|
| 1. | 04 сарын 24-ний өдөр | 29 | 50 |
| 2. | 06 сарын 07-ны өдөр | 19 | 28 |
| 3. | 06 сарын 14-ний өдөр | 10 | 31 |
| 4. | 09 сарын 06-ны өдөр | 25 | 41 |
| 5. | 11 сарын 17-ны өдөр | 28 | 35 |
| 5 удаагийн дуудлага худалдаа | | 111 | 185 |